

| NSW муж улсын боловсролын яам

COVID-19 вирустэй тэмцэх шинэчилсэн зөвлөгөө

[NSW Health](#) нь COVID-19-ийн талаарх зөвлөмжийг 2020 оны 8 сарын 14-нд шинэчлэн баталсан. Энэхүү шинэчилсэн зөвлөмж ёсоор сургуулиуд үйл ажиллагаандаа зохих өөрчлөлтүүдийг оруулж байгаа болно.

1. Хэрэв хүүхдэд ханиад томууны хөнгөн ч гэсэн шинж тэмдэг илэрч байвал тухайн хүүхэд гэртээ байх хэрэгтэй. Сургууль дээр байх үедээ өвдсөн хүүхдийг тусгайлан бэлдсэн өрөөнд тусад нь байлгаж, эцэг эхээр нь хүүхдийг ирж авахуулах ажлыг сургууль зохион байгуулах болно.
 - Өвчтэй эсвэл ханиад, томууны ялимгүй ч гэсэн шинж тэмдэгтэй иргэдийг өөрийн өрхийн эмчээрээ дамжуулан эсвэл орон нутгийнхаа [COVID-19-ийн](#) эмнэлэгт очин шинжилгээ өгөхийг сургуулиуд хүсч байхыг NSW мужийн эрүүл мэндийн яам зөвлөмж болгосон болно.
 - Ханиад, томуу өвчний шинж тэмдэг илэрсэн багш, ажилтан, сурагчид COVID-19 шинжилгээний хариу нь сөрөг гарсан үед л сургуульд буцаж ирэхийг зөвшөөрнө.
2. Бололцоот ойрын хавьтлыг аль болох хязгаарлах зорилгоор сурагчид сургуулийн арга хэмжээнүүдэд оролцохдоо аль болох өөрийн байнга хичээллэдэг хамт олонтойгоо (анги, баг, түвшин гэх мэт) байхаар бодож зохион байгуулах болно.
3. Нэн хэрэгцээтэй биш шалтгаанаар гадны зочид сургуульд ирэхийг хориглоно. Хэрвээ танд багш эсвэл сургуулийн ажилтантай холбогдох шаардлага гарвал сургууль руу утсаар залган цаг аваарай. Уулзалтыг утсаар эсвэл видео уулзалт маягаар зохион байгуулах болно.
4. Сургууль хоорондын арга хэмжээнүүд нь тухайн орон нутаг, дүүрэгтээ л зохион байгуулагдана. Спортын тэмцээн, наадам эсвэл үүнтэй ижил төстэй хүмүүс олноор цуглардаг арга хэмжээнд хоёроос олон тооны сургууль оролцохыг хориглоно.
5. Дуу хөгжмийн дугуйлангууд (найрал дуу), үлээвэр хөгжмийн зэмсэг хэрэглэн найрал хөгжмийн сургуулилалт, тоглолтууд хийхийг хориглоно. Ахлах сургуулийн гэрчилгээ (HSC)-гээ авахаар бэлтгэж буй сурагчдад үүнийг тусгайлан зохион байгуулах болно.
6. Year 11 болон Year 12-р ангиа (HSC) төгсөх сурагчид судалж буй хичээлтэй нь холбоотой анги/арга хэмжээнд оролцох зорилгоор өөр кампус дээр очихыг зөвшөөрнө. Year 11-р ангийг оролцуулан бусад бүх сурагчид, мөн HSC-г төгсөхгүй сурагчид өөр кампус дээр Term 3-ыг дуустал очихыг хориглоно. TAFE болон бусад VET сургалтууд үргэлжлүүлэн явагдах болно.

2021 онд цэцэрлэгүүд хэзээ эхлэх нь одоогоор тодорхойгүй байгаа ч гэсэн хэрэгтэй зөвлөмжүүд [department's website](#) (яамны вебсайт-д) нийтлэгдсэн байгаа. Эдгээр зөвлөмж нь сурагчыг цэцэрлэгт хүсэл сонирхолтой, идэвхитэйгээр шилжин суралцахад нь туслах зорилготой юм.

Эдгээр өөрчлөлтийн талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл сургуультай холбогдон цаг товлон мэдээлэл аваарай.

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл сургуулийн захирал руу залгаарай. Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний Төвтэй 131 450 дугаараар холбогдон өөрийн хэлний орчуулагчтай холбож өгөхийг хүсээрэй. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй болно.